# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 17 (398)

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

- *Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтыг батлах тухай*
- *Үндсэн чиглэл батлах тухай (Монгол Улсын хууль тогтоомжийг 2008 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл)*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2005 он

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Долоо хоног тутмын

Улаанбаатар хот 2005 оны тавдугаар сарын 7 №17 (398)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

689. Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтыг батлах тухай — Дугаар 25 — 381

690. Үндсэн чиглэл батлах тухай — Дугаар 26 — 384

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

**2005 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр** **Дугаар 25** **Улаанбаатар хот**

### Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтыг батлах тухай

2000 онд болсон Нэгдсэн Үндэстний Байгууллага /НҮБ/-ын Мянганы дээд хэмжээний чуулга уулзалтаас баталсан "Мянганы тунхаглал" баримт бичгийг сайшаан Мянганы хөгжлийн зорилтуудад тулгуурлан Монгол Улсын мянганы хөгжлийн 2015 он хүртлэх зорилтыг тодорхойлох, түүнийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавих асуудлыг үндэсний хэмжээнд зохицуулан, зохион байгуулах шаардлагад үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтыг хавсралтаар батлсугай.

2. Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /Ц.Элбэгдорж/-т үүрэг болгосугай:

1/ Мянганы хөгжлийн зорилтуудыг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэл болон цаашид батлан гаргах хөгжлийн баримт бичгүүдэд тусган хэрэгжүүлэх, Мянганы хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тухайн жилийн улсын төсөвт тусгах;

2/ Мянганы хөгжлийн зорилтын хэрэгжилтийн талаарх үндэсний илтгэлийг 2 жил тутам гаргаж, Улсын Их Хурлын хаврын чуулганд танилцуулж байх;

3/ Мянганы хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахад иргэний нийгмийн оролцоог хангах, төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн хооронд түншлэлийг бий болгож, тэдгээрийн үр ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх;

4/ Мянганы хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхдээ дотоодын нөөц бололцоог ашиглахын зэрэгцээ олон улсын банк, санхүүгийн байгууллагын дэмжлэгийг авч, гадаад эх үүсвэрээр хангах боломжтой бүх арга хэмжээг авах талаар санаачлагатай ажиллах.

3. Мянганы хөгжлийн зорилтын хэрэгжилтийг дүгнэх статистикийн шалгуур үзүүлэлтүүдийг мэргэжлийн байгууллагуудтай хамтран тодорхойлох, статистикийн мэдээллийн сан бий болгох, холбогдох байгууллагуудыг мэдээллийн үйлчилгээгээр шуурхай хангаж ажиллахыг Үндэсний статистикийн газар /П.Бямбацэрэн/-т даалгасугай.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн байгуулалтын байнгын хороо /С.Батболд/, Байгаль орчны байнгын хороо /Ч.Раднаа/, Эдийн засгийн байнгын хороо /Ц.Дамиран/, Нийгмийн бодлогын байнгын хороо /С.Ламбаа/, Төсвийн байнгын хороо /Р.Бадамдамдин/-нд тус тус даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**

*Монгол Улсын Их Хурлын 2005 оны 25 дугаар тогтоолын хавсралт*

## МОНГОЛ УЛСЫН МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ

### ЗОРИЛГО НЭГ. ЯДУУРАЛ, ӨЛСГӨЛӨНГ БУУРУУЛАХ

Зорилт 1: Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдийн эзлэх хувь хэмжээг 1990 онтой харьцуулахад 2015 онд 2 дахин бууруулах.

Ядуурлын түвшин:

| 1990 | 2000 | 2015 |
|---|---|---|
| 36 | 35 | 18 |

Зорилт 2: Хоол, тэжээлийн дутагдалтай хүн амын тоог 1990 онтой харьцуулахад 2015 онд 2 дахин бууруулах.

Тураалтай хүүхдийн хувь:

| 1990 | 2000 | 2015 |
|---|---|---|
| 12 | 12 | 0 |

Зорилт 3: Залуучуудад зориулсан таатай, бүтээмж өндөртэй ажлын байр бий болгох стратеги боловсруулж, хэрэгжүүлэх. Газар ашиглах боломжийг нэмэгдүүлэх, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх журмыг хөнгөвчлөх, ажил эрхлээгүй иргэн бичил зээл авах боломжийг бий болгох замаар ажилгүй хүмүүс ялангуяа залуучуудад зориулсан ажлын байрыг бий болгоно.

Зорилт 4: Хүн амын төвлөрөл, шилжих хөдөлгөөнтэй холбогдон гарч буй сөрөг үзэгдлийг багасгах, шилжигсдийн эрх ашгийг хамгаалах, эрх зүйн хамгаалалтыг бий болгох, ажлын байраар хангах, орон сууц, эмнэлэг, боловсрол, соёлын болон нийгмийн бусад үйлчилгээнд хамруулах тогтолцоог бүрдүүлэх.

### ЗОРИЛГО ХОЁР. БҮХ НИЙТЭЭР АНХАН ШАТНЫ БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХ

Зорилт 5: 2015 он гэхэд бүх хүүхдэд бага боловсрол олгох.

Бага боловсролын хамран сургалтын цэвэр жин:

| 1990 | 2000 | 2015 |
|---|---|---|
| | 91 | 100 |

Нэгдүгээр ангид элсэн ороод 5 дугаар анги хүртэл суралцагчдын хувь:

| 1990 | 2000 | 2015 |
|---|---|---|
| 91 | 84 | 100 |

15-24 насны залуусын бичиг үсэг тайлагдалтын хувь:

| 1990 | 2000 | 2015 |
|---|---|---|
| 99 | 98 | 100 |

### ЗОРИЛГО ГУРАВ. ХҮЙСИЙН ТЭГШ БАЙДЛЫГ ДЭМЖИН ХӨГЖҮҮЛЖ, ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВШИНД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ

Зорилт 6 2005 онд бага болон дунд боловсрол эзэмшигчдийн дунд, 2015 он гэхэд бүх шатны боловсролын түвшинд хүйсийн ялгааг арилгах.

Бага боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн тооны харьцаа:

| 1990 | 2000 | 2015 |
|---|---|---|
| 1.01 | 1.01 | 1.00 |

Ерөнхий боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн тооны харьцаа:

| 1990 | 2000 | 2015 |
|---|---|---|
| 1.12 | 1.20 | 1.00 |

Дээд боловсрол эзэмшиж байгаа эмэгтэй, эрэгтэйчүүдийн тооны харьцаа:

| 1990 | 2000 | 2015 |
|---|---|---|
| 1.56 | 1.72 | 1.00 |

ХАА-гаас бусад салбарт цалинтай ажил эрхэлж байгаа хүн амын дотор эмэгтэйчүүдийн эзлэх хувь:

| 1990 | 2000 | 2015 |
|---|---|---|
| - | 47 | 50 |

Үндэсний парламентад сонгогдсон эмэгтэйчүүдийн эзлэх хувь:

| 1990 | 2000 | 2015 |
|---|---|---|
| 4 | 12 | 30 |

Үндэсний парламентад нэр дэвшсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь:

| 2000 | 2004 | 2008 | 2012 |
|---|---|---|---|
| 11.5 | 13.7 | 20 | 35 |

**ЗОРИЛГО ДӨРӨВ. ХҮҮХДИЙН ЭНДЭГДЛИЙГ БУУРУУЛАХ**

Зорилт 7: 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 1990 онтой харьцуулахад 2015 онд гуравны хоёроор бууруулах.

5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин:
/1000 амьд төрөлт тутамд/

| 1990 | 2000 | 2015 |
|---|---|---|
| 87.5 | 42.4 | 29.2 |

Нялхсын эндэгдлийн түвшин :
/1000 амьд төрөлт тутамд/

| 1990 | 2000 | 2015 |
|---|---|---|
| 63.4 | 32.8 | 22.0 |

Улаан бурхны эсрэг вакцинжуулалтад хамрагдсан хүүхдийн хувь:

| 1990 | 2000 | 2015 |
|---|---|---|
| 82.5 | 92.4 | 96 |

**ЗОРИЛГО ТАВ. ЭХЧҮҮДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ САЙЖРУУЛАХ**

Зорилт 8: Нөхөн үржихүйн эрүүл мэндийн шаардлагатай тусламж үйлчилгээг хүн бүрт хүргэж, эхийн эндэгдлийг 1990 онтой харьцуулахад 2015 онд дөрөвний гурваар бууруулах.

Эхийн эндэгдлийн түвшин/100000 амьд төрөлт бүрт/:

| 1990 | 2000 | 2015 |
|---|---|---|
| 200 | 158. | 50 |

Эрүүл мэндийн мэргэжлийн ажилтан эх барьсан төрөлтийн хувь:

| 1990 | 2000 | 2015 |
|---|---|---|
| 99.9 | 99.6 | 99.8 |

**ЗОРИЛГО ЗУРГАА. БЭЛГИЙН ЗАМЫН ХАЛДВАРТ ӨВЧИН, ХҮНИЙ ДАРХЛАЛЫН ХАЛДВАРТ ВИРУС /ХДХВ/, ДОХ, СҮРЬЕЭТЭЙ ТЭМЦЭХ, БУСАД ӨВЧНИЙГ БУУРУУЛАХ**

Зорилт 9 2015 он гэхэд Хүний дархлалын халдварт вирус /ХДХВ/, Дархлалын олдмол вирус /ДОХ/ өвчний халдварыг хязгаарлах, урьдчилан сэргийлэх.

Зорилт 10: 2015 он гэхэд сүрьеэ өвчний тархалтыг бууруулах.
Сүрьеэ өвчний тархалт/100000 хүн тутамд/:

| 1990 | 2000 | 2004 | 2015 |
|---|---|---|---|
| 79 | 125 | 177 | 100 |

Сүрьеэ өвчнөөс шалтгаалсан нас баралтын түвшин /100000 хүн тутамд/:

| 1990 | 2000 | 2015 |
|---|---|---|
| 4.9 | 3.2 | 0 |

Оношилгоо, эмчилгээний олон улсын стандартын хүрээнд илрүүлж, эмчилсэн сүрьеэгийн тохиолдлын хувь:

| 1990 | 2000 | 2015 |
|---|---|---|
| | 100 | 100 |

Зорилт 11: Хүн амын шүдний өвчлөлтэй тэмцэх тусгай хөтөлбөр хэрэгжүүлэх.

**ЗОРИЛГО ДОЛОО. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ**

Зорилт 12: Тогтвортой хөгжлийн зарчмыг улсын хөгжлийн бодлого, хөтөлбөрт тусган хэрэгжүүлж, хот суурин, ялангуяа Улаанбаатар хотын агаарыг цэвэршүүлэх.
Ойт нутгийн эзлэх хувь:

| 1990 | 2000 | 2015 |
|---|---|---|
| 9 | 8.2 | 9 |

Улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийн эзлэх хувь:

| 1990 | 2000 | 2015 |
|---|---|---|
| 7 | 13.3 | 30.0 Тайлбар: Үүнээс 15.0 хувийг орон нутгийн тусгай хамгаалалтад авна |

Нэг хүнд ногдох нүүрсхүчлийн давхар эслийн ялгаралт (тонн/хүн):

| 1990 | 2000 | 2004 | 2015 |
|---|---|---|---|
| 4.08 | 4.19 | 5.61 | 4.00 |

Зорилт 13: Гол, горхины усны эхийг хамгаалж, нөхөн сэргээх замаар ширгэлтийг багасгах.

Зорилт 14: 2015 он гэхэд баталгаат үндны ус хэрэглэх боломжгүй хүн амын эзлэх хувийг 2 дахин бууруулах.

Баталгаат эх үүсвэрээс ус хэрэглэж байгаа хүн амын эзлэх хувь:

| 1990 | 2000 | 2015 |
|---|---|---|
| 30.8 | 37 | 70 |

Зорилт 15: 2015 гэхэд орон байрны нөхцөл муу хүмүүсийн аж байдлыг мэдэгдэхүйц сайжруулах.

Эрүүл ахуйн шаардлага хангахуйц нөхцөлд амьдарч байгаа хүн амын эзлэх хувь:

| 1990 | 2000 | 2015 |
|---|---|---|
| 22 | 25 | 50 |

**ЗОРИЛГО НАЙМ. ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ДЭЛХИЙ НИЙТИЙН ТҮНШЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ**

Зорилт 16: Худалдааны болон санхүүгийн тогтолцоог хөгжүүлэх замаар Мянганы хөгжлийн зорилтуудад хүрэх таатай нөхцөл бүрдүүлэх.

Зорилт 17: Далайд гарцгүй Монгол орны онцгой хэрэгцээ, шаардлагыг харгалзан Монгол Улс илүү тааламжтай нөхцөлөөр далайд гарцтай болох, гадаадад дамжин өнгөрөх тээврийн үр ашгийг дээшлүүлэх, Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх тээврийг өргөжүүлэх.

Зорилт 18: Урт хугацаанд гадаад, дотоод өрийн тогтвортой байдлыг хангах үүднээс өрийн стратегийг бий болгох, үндэсний болон олон улсад хэрэглэж байгаа арга хэрэгслийг судалж, Монгол Улсын төсөв, эдийн засагт хүндрэл учруулахгүйгээр өрийг зохицуулан шийдвэрлэж байх.

Зорилт 19: Мэдээлэл холбооны шинэ технологийг хөгжүүлэх, "Мэдээлэлжсэн нийгэм" байгуулах.

**ЗОРИЛГО ЕС. ХҮНИЙ ЭРХИЙГ БАТАЛГААЖУУЛАХ, АРДЧИЛСАН ЗАСАГЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ**

Зорилт 20: Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг хүндэтгэж, чандлан сахих, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангаж, олон нийтэд мэдээллийг чөлөөтэй олж авах боломж олгох.

Зорилт 21: Ардчиллын үндсэн зарчим, хэв маягийг амьдралд хэвшүүлэх.

Зорилт 22: Авилгалыг үл тэвчих уур амьсгалыг нийгмийн бүх хүрээнд бий болгон хэвшүүлэх.

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

**2005 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр** | **Дугаар 26** | **Улаанбаатар хот**

**Үндсэн чиглэл батлах тухай**

Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын хууль тогтоомжийг 2008 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэлийг хавсралтаар баталсугай.

2.Монгол Улсын хууль тогтоомжийг 2008 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэлийн биелэлтийг зохион байгуулж хангах, түүний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засгийн газар /Ц.Элбэгдорж/, холбогдох Байнгын хороодын дарга нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**

26 дугаар тогтоолын хавсралт

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ 2008 ОН ХҮРТЭЛ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

| № | Төслийн нэр | Санаачлах байгууллага, албан тушаалтан | Хариуцан боловсруулах байгууллага, албан тушаалтан | Хуга-цаа | Тухайн хуулиар зохицуулах харилцааны товч утга | Хяналт тавих Байнгын хороо |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Нэг.ХУУЛИЙН ТӨСӨЛ | | | |
| 1.ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР: | | | | | | |
| 1 | Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Хууль зүй, дотоод хэргийн яам, Төрийн албаны зөвлөл | 2005 | Төрийн жинхэнэ албан хаагчдыг намын харъяалалгүй болгох, албан хаагчдын хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох, улс төрийн албан хаагчдын хүрээг багасгах, сонгуульд нэр дэвшсэнээр төрийн албанаас чөлөөлөгддөг жишиг тогтоох | Төрийн байгуулалтын байнгын хороо |
| 2 | Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Улсын мэргэжлийн хяналтын газар | 2005 | Захиргааны улсын байцаагчийн эрх, үүргийг тодорхой болгох | Төрийн байгуулалтын байнгын хороо |
| 3 | Төрийн аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Үндэсний аудитын газар | 2005 | Аймаг, нийслэлийн аудитын газар, Ерөнхий аудиторын бүрэн эрх, чиг үүргийг өргөжүүлэх | Төрийн байгуулалтын байнгын хороо |
| 4 | Аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Үндэсний аудитын газар | 2005 | Төрийн болон орон нутгийн өмчийн, түүнчлэн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн аудиторыг томилох асуудлыг Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд нийцүүлэх | Эдийн засгийн байнгын хороо |
| 5 | Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам | 2006 | Төрийн сүлд, далбааг өргөнөөр хүндэтгэн хэрэглэх, эх орноороо бахархах хүмүүжил олгох | Төрийн байгуулалтын байнгын хороо |
| 6 | Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Шадар сайд, Барилга, хот байгуулалтын яам, Хууль зүй, дотоод хэргийн яам | 2005 | Нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох | Төрийн байгуулалтын байнгын хороо |
| 7 | Улсын Их Хурлын сонгуулийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Улсын Их Хурлын гишүүд | Улсын Их Хурлын гишүүд | 2005 | Сонгуулийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох | Төрийн байгуулалтын байнгын хороо |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 8 | Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Д.Бат-Эрдэнэ, С.Ламбаа, Р.Раш | Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Д.Бат-Эрдэнэ, С.Ламбаа, Р.Раш | 2005 | Морины уралдаан, уяачдын цолны болзлыг зохицуулсан харилцааг боловсронгуй болгох | Төрийн байгуулалтын байнгын хороо |
| **2.НИЙГМИЙН БОДЛОГЫН ЧИГЛЭЛЭЭР:** | | | | | | |
| 9 | Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Үйлдвэр, худалдааны яам, Сангийн яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам | 2005-2006 | Нийгмийн даатгалын шимтгэлийн хэмжээг бууруулах, албан бус болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг нийгмийн даатгалд хамруулах зохицуулалтыг боловсронгуй болгох | Нийгмийн бодлогын байнгын хороо |
| 10 | Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Сангийн яам | 2005-2006 | Тэтгэврийн хэмжээг хэрэглээний үнийн индексээр нэмэгдүүлэх, тэтгэврийн болон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг уялдуулдаг тогтолцоог халах, тэтгэврийн даатгалын санд ажил олгогчийн төлөх шимтгэлийг бууруулах замаар ажил олгогч, даатгуулагчийн тэтгэврийн даатгалд төлөх шимтгэлийн зохистой харьцааг тогтоох, эмэгтэйчүүдийн тэтгэвэрт гарах насыг нэмэгдүүлэх, тахир дутуу, тэжээгчээ алдсны тэтгэвэр бодох аргачлалыг өөрчлөх | Нийгмийн бодлогын байнгын хороо |
| 11 | Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Эрүүл мэндийн яам, Сангийн яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам | 2005 | Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийг тусламж, үйлчилгээний чанартай уялдуулах, даатгалаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний хүрээг өргөтгөх, даатгуулагчийн эрхийг баталгаажуулах, даатгалд хамруулах асуудлаар иргэн, байгууллагуудын хариуцлагыг өндөржүүлэх | Нийгмийн бодлогын байнгын хороо |
| 12 | Нийгмийн халамжийн тухай /шинэчилсэн найруулга/ | Засгийн газар | Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Сангийн яам | 2006 | Тэтгэвэр, тэтгэмж болон тусламж, үйлчилгээний бүтэц, агуулгыг шинэчлэх, нийгмийн халамжид хамрагдах иргэдийг сонгох шалгуур үзүүлэлтүүдийг өөрчлөх, нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудын эрх зүйн үндсийг бүрдүүлэх, жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлж, даатгуулагчийн авч байсан цалин, орлогын 100 хувьд хүргэх, тавааас доош жил шимтгэл | Нийгмийн бодлогын байнгын хороо |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төлж ажилласан даатгуулагчид олгох ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээг авч байсан цалин, орлогын 50 хувьд хүргэж нэмэгдүүлэн хуанлийн 6 сар хүртэл хугацаанд ногдох ажлын өдрөөр тооцож олгодог болох, төрөлхийн саажилттай хүүхдээ асарсан эх /эцэг/-ийн хүүхдээ асарсан хугацааг ажилласан жилд оруулан тооцож, тэтгэвэр, тэтгэмжид хамруулах | |
| 13 | Ахмад настан, түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам | 2005-2006 | Ахмад настны нийгмийн хамгааллыг сайжруулах, ахмад дайчид, улсын цолтонд тусламж, тэтгэмж олгох асуудлыг өөрчлөх | Нийгмийн бодлогын байнгын хороо |
| 14 | Тахир дутуу хүний нийгмийн хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам | 2005-2006 | Нэр томъёо, хамрах хүрээ, үйлчилгээг өөрчлөх | Нийгмийн бодлогын байнгын хороо |
| 15 | Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Улсын Их Хурлын гишүүн Д.Дондог, С.Ламбаа | Улсын Их Хурлын гишүүн Д.Дондог, С.Ламбаа | 2007 | Аж ахуйн нэгж, байгууллагын нийт ажиллагчдын 5 хувьд багтаан амьжиргааны доод түвшингээс доогуур орлоготой өрхийн 1 хүнийг ажиллуулж байхаар зохицуулах | Нийгмийн бодлогын байнгын хороо |
| 16 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам | 2005 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас дэмжлэг үзүүлэх нийгмийн бүлгүүдийг оновчтой тогтоох, малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд тохирсон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ бий болгох, уг сангийн хөрөнгийг зарцуулах эрх мэдлийг орон нутагт нэмэгдүүлэх, нийгмийн онцлог бүлгийнхэнд тохирсон хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ бий болгох, жижиг зээлийн үйлчилгээг боловсронгуй болгох | Нийгмийн бодлогын байнгын хороо |
| 17 | Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай /шинэчилсэн найруулга/ | Засгийн газар | Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Гадаад хэргийн яам | 2005 | Гадаадад хөдөлмөр эрхлэхэд зуучлах үйлчилгээ, гадаадаас ажиллах хүч авахтай холбогдсон харилцааг боловсронгуй болгох, гадаадад хөдөлмөр эрхлэгчдэд зориулсан үйлчилгээг өргөжүүлэх, гадаадад хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан бүтэц, зохион байгуулалтыг өргөжүүлэх | Нийгмийн бодлогын байнгын хороо |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 18 | Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн тухай | Улсын Их Хурлын гишүүн Д.Бат-Эрдэнэ, Ч.Авдай, Г.Адьяа, С.Ламбаа | Улсын Их Хурлын гишүүн Д.Бат-Эрдэнэ, Ч.Авдай, Г.Адьяа, С.Ламбаа, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам | 2005-2006 | Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандартыг тогтоох, ажлын байранд тавих ерөнхий шаардлага, тодорхой үйлдвэрлэлийн барилга байгууламж, тоног төхөөрөмж, ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл зэрэгт тавих шаардлага, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандартыг хангаагүй аж ахуйн нэгж, байгууллагад хүлээлгэх хариуцлагын тогтолцоог оновчтой тогтоох | Нийгмийн бодлогын байнгын хороо |
| 19 | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогын улмаас тахир дутуу болсон иргэнд нөхөн төлбөр олгох тухай | Засгийн газар | Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам | 2005-2006 | Хөдөлмөрийн тухай хуульд заасан үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогын улмаас тахир дутуу болсон, түүнчлэн ажил олгогч нь дампуурсан, татан буугдсаны улмаас хариуцагчгүй болсон иргэнд нөхөн олговор олгохтой холбогдох харилцааг зохицуулах | Нийгмийн бодлогын байнгын хороо |
| 20 | Гэр бүлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Хууль зүй, дотоод хэргийн яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам | 2006 | Гадаадын иргэнд Монгол Улсын харъяат хүүхдийг үрчлүүлэх харилцааг боловсронгуй болгох, тухайлбал, хүүхдийн насны хязгаар, үрчлэгдэх боломж, үрчлэгдсэн хүүхдийн эрхийг хамгаалах, үрчлэгдсэн хүүхдийн талаархи мэдээллийн тогтолцоо бүрдүүлэх | Нийгмийн бодлогын болон Хууль зүйн байнгын хороод |
| 21 | Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Эрүүл мэндийн яам, Улсын мэргэжлийн хяналтын газар | 2005 | Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах байгууллагад тусгай зөвшөөрөл олгох, магадлан итгэмжлэх, эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох үйл ажиллагааг чирэгдэл, давхардалгүй болгох, эрүүл мэндийг дэмжихэд нийгмийн нөөцийг дайчлах, орон нутгийн шийдвэр гаргагчдаас дэмжлэг авах зохицуулалт бий болгох, зах зээлийн өнөөгийн нөхцөлд иргэдийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн тусламж үйлчилгээг үзүүлж, тэдний ашиг сонирхлыг хөндөхгүйгээр эрүүл мэндийн салбар хөгжих, тэнд ажиллаж буй эмнэлгийн мэргэжилтнүүдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх боломж бүрдүүлэх | Нийгмийн бодлогын байнгын хороо |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 22 | Эмийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Эрүүл мэндийн яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам, Улсын мэргэжлийн хяналтын газар | 2005-2006 | Эмийн аюулгүй байдлыг хангах, эм, эмнэлгийн хэрэгслийг импортлох, түгээх, худалдах үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг дээшлүүлэх, эмийг ашиг олох хэрэгсэл болгох үйл ажиллагаанд хяналт тавих, өндөр идэвхтэй, аюулгүй, чанарын баталгаатай эмээр эмнэлгийн байгууллага, хүн амыг тасралтгүй, жигд, хүртээмжтэй хангаж, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг чангатгах | Нийгмийн бодлогын байнгын хороо |
| 23 | Тамхины хор хөнөөлтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Эрүүл мэндийн яам | 2005 | 2005 оны 2 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болсон Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Тамхины хяналтын суурь Конвенцид нэгдэн орсон орны хувьд хүлээсэн үүргийнхээ дагуу уг Конвенцид тусгагдсан ерөнхий зарчим, арга хэмжээг өөрийн орны нөхцөл байдалд нийцүүлэн, тамхины хяналтын төрийн удирдлага, зохион байгуулалт, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх | Нийгмийн бодлогын байнгын хороо |
| 24 | Ариун цэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Улсын мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн яам | 2005 | Эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, ариун цэврийн дэг журмыг сайжруулахтай холбогдсон шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах, хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг нэмэгдүүлэх | Нийгмийн бодлогын байнгын хороо |
| 25 | Эхийн сүү орлуулах бүтээгдэхүүний тухай | Улсын Их Хурлын гишүүн Л.Одончимэд, Д.Туяа | Улсын Их Хурлын гишүүн Л.Одончимэд, Д.Туяа | 2005 | Эхийн сүүг орлуулах бүтээгдэхүүнийг импортлох, үйлдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах | Нийгмийн бодлогын байнгын хороо |
| 26 | Өвчтөний эрхийг хамгаалах тухай | Улсын Их Хурлын гишүүн Т.Ганди, Л.Одончимэд, Д.Туяа | Улсын Их Хурлын гишүүн Т.Ганди, Л.Одончимэд, Д.Туяа | 2006 | Олон улсын конвенцийн дагуу хүнд өвчтэй, хөнгөлөлт, тусгай үйлчилгээнд хамрагдах өвчтөн /хавдар, чихрийн шижин, ДОХ г.м. удаан хугацааны эмчилгээ шаардагдах/-ий эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулах | Нийгмийн бодлогын байнгын хороо |
| 27 | Боловсролын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам | 2005 | Ерөнхий боловсролын сургуулийн тогтолцоог 12 жилд шилжүүлэх, боловсролын агуулга, стандартын шинэчлэлийг гүнзгийрүүлэх, сургуулийн санхүүжилт, удирдлагын асуудлыг бусад хуультай нийцүүлэн боловсронгуй болгох | Боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 28 | Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам | 2005-2006 | Төрийн өмчийн эрдэм шинжилгээний бие даасан байгууллага байгуулах, татан буулгах, шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаатай холбоотой нийтээр дагаж мөрдөх дүрэм, журмыг батлах асуудлыг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцдаг байх | Боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо |
| 29 | Шинжлэх ухааны Академийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Улсын Их Хурлын гишүүн А.Бакей, Н.Баяртсайхан А.Цанжид, Б.Эрдэнэсүрэн | Улсын Их Хурлын гишүүн А.Бакей, Н.Баяртсайхан, А.Цанжид, Б.Эрдэнэсүрэн | 2005-2006 | Шинжлэх ухааны Академийн эрх зүйн байдлыг оновчтой болгож, салбарын шинжлэх ухааны байгууллагын эрх, үүрэг, төрийн захиргааны төв байгууллагатай харилцах харилцааны асуудлыг зохицуулах | Боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо |
| 30 | Соёлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам | 2006 | Соёл, урлагийн байгууллагын удирдлага болон уран бүтээлчдийн ёс зүй, хувьчлалын асуудал болон ном, хэвлэл, цахим бичвэрийн талаарх зохицуулалтыг хуульд тодорхой тусгах | Боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо |
| 31 | Эрдмийн зэрэг, цолны тухай | Улсын Их Хурлын гишүүн Ч.Содномцэрэн | Улсын Их Хурлын гишүүн Ч.Содномцэрэн | 2006-2007 | Эрдмийн зэрэг, цол олгох, түүнийг олгох байгууллагын эрх хэмжээтэй холбогдсон харилцааг зохицуулах | Боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо |
| **3. ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН БОДЛОГЫН ЧИГЛЭЛЭЭР:** | | | | | | |
| 32 | Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай тэмцэх тухай | Засгийн газар | Сангийн яам, Монголбанк, Үнэт цаасны хороо | 2005 | Банк, санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангах эрх зүйн орчинг боловсронгуй болгох, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх үйл ажиллагаатай холбогдох харилцааг зохицуулах | Эдийн засгийн болон Хууль зүйн байнгын хороод |
| 33 | Хадгаламжийн даатгалын тухай | Засгийн газар | Сангийн яам, Монголбанк | 2005 | Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хадгаламжийн даатгалын үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндсийг бүрдүүлэх, даатгалд хамрагдах хадгаламжийн хэлбэр, хэмжээг тогтоох, хадгаламжийн даатгалын байгууллагыг үүсгэн байгуулах, түүний удирдлага, зохион байгуулалт, эрх, үүрэг, хариуцлагыг зохицуулах | Эдийн засгийн байнгын хороо |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 34 | Татварын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Сангийн яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам | 2005-2006 | Татварын талаар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор татварын харилцааг иж бүрнээр нь судлан үзэж, татварын зарим орлогыг орон нутагт шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх, аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварыг нэг шатлалд шилжүүлэх, импортын татварын зохистой харьцааг тогтоох, импортын барааны гаалийн татварт жишиг үнэ хэрэглэхгүй байх, хүн амын орлого, амьжиргааны түвшинг татвартай уялдуулах, хүн амын орлогын албан татварын хөнгөлөлтийн доод хэмжээг 2005 онд 60000 төгрөгт хүргэхээр Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2005-2006 оны улсын хэлэлцээрт Засгийн газраас оруулж буй саналыг хэрэгжүүлэх, татварын суурийг өргөтгөх, татвар тэгш, шударга байх зарчмыг хэрэгжүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжих болон салбараар ялгаварласан аливаа хөнгөлөлт, чөлөөлөлтийг багасгахад чиглэсэн өөрчлөлтүүд оруулах, татварын өршөөлийн тухай асуудлыг зохицуулах | Төсвийн байнгын хороо |
| 35 | Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Сангийн яам, Үйлдвэр, худалдааны яам, Монголбанк | 2005 | Тогтвортой байдлын гэрээний зохицуулалтыг нарийвчлан, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг дэмжих эрх зүйн орчинг боловсронгуй болгох | Эдийн засгийн байнгын хороо |
| 36 | Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Сангийн яам, Үндэсний аудитын газар, Улсын мэргэжлийн хяналтын газар | 2005 | Байгууллагын нягтлан бодогчийн ур чадварыг дээшлүүлэх, улмаар татварын орлого бүрдүүлэлтийг сайжруулах зорилгоор нягтлан бодогчоор ажиллах эрх олгох, түүнд тавигдах шаардлагыг тогтоох, төрийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайланг эцэслэн гаргах хугацааг оновчтой тогтоох, түүнчлэн хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, хариуцлага хүлээлгэх субъектыг бүрэн хамруулах чиглэлээр нэмэлт, өөрчлөлт оруулах | Төсвийн байнгын хороо |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 37 | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай /шинэчилсэн найруулга/ | Засгийн газар | Сангийн яам | 2005 | Төсвийн удирдлага, санхүүжилтийн шинэ тогтолцоонд нийцүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтын болон бараа, үйлчилгээний зарлагын үр ашгийг сайжруулах боломжийг нэмэгдүүлэх, түүнчлэн хуулийг хэрэгжүүлэх явцад гарч буй хүндрэл, бэрхшээлийг арилгах, хуулийн хэрэгжилтэд тавих хяналтын тогтолцоог боловсронгуй болгох | Эдийн засгийн болон холбогдох байнгын хороод |
| 38 | Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Улсын мэргэжлийн хяналтын газар, Үндэсний аудитын газар | 2005 | Шалгалтаар тогтоож төлбөр бичигдсэн актын биелэлтийг хангах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, төрийн сан дахь төсвийн сангийн данснаас хасалт хийхэд Төсвийн ерөнхийлөн захирагчийн бичгээр өгсөн зөвшөөрлийг үндэслэж байх, төсвийн байгууллага, төрийн өмчийн аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланг эцэслэн гаргах, түүнд аудит хийх, хийлгэх хугацааг оновчтой тогтоох талаар нэмэлт, өөрчлөлт оруулах | Төсвийн байнгын хороо |
| 39 | Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Сангийн яам | 2005 | Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг ногдуулах асуудлыг олон улсын жишигт нийцүүлэн зохицуулах, үл хөдлөх эд хөрөнгийн татварын суурийг өргөжүүлэн хувь хэмжээг нь зохистой тогтоох | Төсвийн байнгын хороо |
| 40 | Хадгаламж зээлийн хоршооны тухай | Засгийн газар | Сангийн яам, Монголбанк, Үнэт цаасны хороо | 2005-2006 | Хадгаламж, зээлийн хоршооны эрх зүйн үндсийг боловсронгуй болгох, тухайлбал, гишүүнчлэлийн асуудал, хувь нийлүүлэх хөрөнгө, зээл олгох, хоршооны гишүүн болон гишүүн бус хүмүүсээс хадгаламж авах, буцаан олгох зэрэг харилцааг нарийвчлан тусгах | Эдийн засгийн байнгын хороо |
| 41 | Малын даатгалын тухай | УИХ-ын гишүүн А.Бакей, Н.Баяртсайхан | УИХ-ын гишүүн А.Бакей, Н.Баяртсайхан, Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам | 2005 | Малыг байгалийн гамшигт үзэгдэл, халдварт өвчнөөс даатгахтай холбогдсон иргэн, даатгалын байгууллагын хоорондын харилцааг зохицуулах | Эдийн засгийн болон Хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороод |
| 42 | Авто тээврийн хэрэгслийг эзэмшигч, өмчлөгчийн даатгалын тухай | Засгийн газар | Сангийн яам, Улсын мэргэжлийн хяналтын газар | 2005 | Бүх төрлийн тээврийн хэрэгслийг өмчлөгч, эзэмшигчдийн хариуцлагыг заавал даатгалд хамруулах, ийм төрлийн даатгал эрхлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах | Эдийн засгийн болон Дэд бүтцийн байнгын хороод |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 43 | Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Зам тээвэр, аялал жуулчлалын яам, Сангийн яам, Монголбанк | 2005 | Дэлхийн шуудан холбооны байгууллагын Санхүүгийн үйлчилгээний нэгдсэн хэлэлцээрт Монгол Улс нэгдэн орсонтой холбогдуулан тус улсын шуудангийн байгууллага банк, санхүүгийн үйлчилгээ эрхлэхтэй холбогдон үүсэх харилцааг нэмж тусгах | Эдийн засгийн болон Дэд бүтцийн байнгын хороод |
| 44 | Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Сангийн яам, Монголбанк, Үнэт цаасны хороо | 2005-2006 | Үнэт цаасны зах зээл, хөрөнгийн биржийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, өмч хувьчлалыг хөрөнгийн биржээр явуулах, үүнтэй холбогдуулан Төрийн өмчийн хорооны чиг үүрэгт өөрчлөлт оруулах | Эдийн засгийн байнгын хороо |
| 45 | Банкин дахь хувийн дансны нууцлалын тухай | Засгийн газар | Сангийн яам, Монголбанк | 2005-2006 | Иргэдийн хувийн дансны нууцлалыг сайжруулах, хувийн дансны нууцлалыг онцгой, өндөр нөхцөлөөр хамгаалах | Эдийн засгийн байнгын хороо |
| 46 | Улсын нөөцийн тухай | Засгийн газар | Онцгой байдлын ерөнхий газар, Хүнс, хөдөө аж ахуйн яам, Сангийн яам | 2005 | Эдийн засгийг тогтвортой байлгах, үндэсний аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор улсын нөөц бүрдүүлэх, хадгалах, шинэчлэх, захиран зарцуулахтай холбогдсон харилцааг зохицуулах | Эдийн засгийн, Аюулгүй байдал, гадаад бодлогын болон Хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороод |
| 47 | Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | Улсын Их Хурлын гишүүн Ч.Авдай | Улсын Их Хурлын гишүүн Ч.Авдай, Стандартчилал, хэмжил зүйн Үндэсний төв | 2005-2006 | Стандарчилал, тохирлын үнэлгээтэй холбогдсон харилцааг олон улсын жишигт нийцүүлэн зохицуулах | Эдийн засгийн байнгын хороо |
| 48 | Итгэмжлэлийн тухай | Улсын Их Хурлын гишүүн Ч.Авдай | Улсын Их Хурлын гишүүн Ч.Авдай, Стандартчилал, хэмжил зүйн Үндэсний төв | 2005-2006 | Тус улсын стандартчилал, хэмжил зүйн байгууллага нь олон улсын лаборатори итгэмжлэлийн хамтын ажиллагааны байгууллагад гишүүнээр элссэнтэй холбогдуулан стандартчилал, тохирлын үнэлгээний ойлголтыг олон улсын жишигт нийцүүлэх | Эдийн засгийн байнгын хороо |
| 49 | Авто замын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Зам тээвэр, аялал жуулчлалын яам | 2005 | Улсын болон орон нутгийн замын сангийн хөрөнгийн хуваарилалт, зарцуулалтыг боловсронгуй болгох, тээвэрлэгчид авто замын даацаас хэтэрсэн ачааг тээвэрлэн авто зам, замын байгууламж, шугам сүлжээг эвдэж, гэмтээн улсад ихээхэн хохирол учруулж байгааг журамлах | Дэд бүтцийн байнгын хороо |
| 50 | Далай ашиглах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Зам тээвэр, аялал жуулчлалын яам, Барилга, хот байгуулалтын яам | 2005 | Далайн тээвэр, хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэн зохицуулах | Дэд бүтцийн байнгын хороо |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 51 | Иргэний нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Зам тээвэр, аялал жуулчлалын яам | 2005 | Орон нутгийн агаарын тээврийг хөгжүүлэх, агаарын тээвэрт хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, тэдэнд дэмжлэг үзүүлэх, иргэний нисэхийн тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгох зэрэг харилцааг тусгах | Дэд бүтцийн байнгын хороо |
| 52 | Төмөр замын тээврийн тухай | Засгийн газар | Зам тээвэр, аялал жуулчлалын яам | 2005 | Нийтийн болон дагнасан хэрэглээний төмөр замын тээврийн эрх зүйн үндсийг бүрдүүлэх, төмөр замыг эзэмшигч, ашиглагчдын хооронд үүсэх харилцааг зохицуулах | Дэд бүтцийн байнгын хороо |
| 53 | Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Зам тээвэр, аялал жуулчлалын яам | 2005-2006 | Шуудангийн зах зээлийн өрсөлдөөнтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах | Дэд бүтцийн байнгын хороо |
| 54 | Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Түлш, эрчим хүчний яам | 2006 | Эрчим хүчний хэрэглээ, эрэлтийг хангах, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг бий болгох, салбарыг арилжааны хэлбэрт оруулах, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, эрчим хүчний үнэ тарифын зохицуулалтыг боловсронгуй болгох | Дэд бүтцийн байнгын хороо |
| 55 | Эрчим хүчний хэмнэлтийн тухай | Засгийн газар | Түлш, эрчим хүчний яам | 2006 | Эрчим хүчийг үр ашигтай хэрэглэх, зарцуулах эрх зүй, зохион байгуулалт, эдийн засгийн тогтолцоог бий болгох, эрчим хүчийг хэрэглэдэг технологи, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, дулаалгын материалыг үйлдвэрлэх, ашиглах, импортлох, эрчим хүчний хоёрдогч нөөц, нөхөн сэргэх эрчим хүчийг ашиглахтай холбогдох харилцааг зохицуулах | Дэд бүтцийн байнгын хороо |
| 56 | Шингэрүүлсэн шатдаг хийн хангамж, аюулгүй байдлын тухай | Засгийн газар | Түлш, эрчим хүчний яам | 2006 | Шингэрүүлсэн шатдаг хийн хангамж, хэрэглээтэй холбогдон гарч болох, хүн амын эрүүл мэнд, эд хөрөнгө, аюулгүй байдалд нөлөөлөх, аваар, осол гарахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн хэрэглэгч, ханган нийлүүлэгч, хяналтын байгууллагуудын эрх, үүрэг, хариуцлагыг зохицуулах | Дэд бүтцийн байнгын хороо |
| 57 | Сэргээгдэх эрчим хүчний тухай | Засгийн газар | Түлш, эрчим хүчний яам | 2006 | Нар, ус, салхи, биомасс, газрын гүний дулаан зэрэг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулах | Дэд бүтцийн байнгын хороо |
| 58 | Газрын тосны бүтээгдэхүүний тухай | Засгийн газар | Үйлдвэр, худалдааны яам | 2005 | Газрын тосны бүтээгдэхүүнийг тээвэрлэх, хадгалах, худалдах, үйлдвэрлэх, уг бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах | Эдийн засгийн байнгын хороо |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 59 | Технологи дамжуулах тухай /шинэчилсэн найруулга/ | Засгийн газар | Үйлдвэр, худалдааны яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам | 2006 | Технологийн дэвшлийг үнэлэх, ашиглах, дэмжих шаардлага, зарчим, урамшуулах тогтолцоо, оролцогчдын эрх, үүрэг, тэдгээрт тавих хяналттай холбогдсон харилцааг тодорхой болгох зэргээр хуулийг бүхэлд нь боловсронгуй болгох | Эдийн засгийн болон Боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороод |
| 60 | Ашигт малтмалыг үйлдвэрлэлийн бус аргаар олборлох тухай | Засгийн газар | Үйлдвэр, худалдааны яам | 2005 | Ашигт малтмалыг үйлдвэрлэлийн бус аргаар олборлох эрх зүйн үндсийг тодорхойлж, энэ үйл ажиллагаатай холбогдон орон нутгийн удирдлага, ашигт малтмалыг ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч болон ашигт малтмалыг гар аргаар олборлож буй иргэдийн хооронд үүсэх харилцааг зохицуулах | Эдийн засгийн байнгын хороо |
| 61 | Лизингийн тухай | Засгийн газар | Үйлдвэр, худалдааны яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам, Сангийн яам, Монголбанк, | 2005 | Техник, тоног төхөөрөмжийг лизингээр ашиглах үйл ажиллагааны зарчим, түүнд тавих шаардлага, оролцогч талуудын эрх, үүрэг, хяналтыг тодорхойлох | Эдийн засгийн байнгын хороо |
| 62 | Бараа, түүхий эдийн олон улсын бирж дээр арилжааны үйл ажиллагаа явуулах тухай | Засгийн газар | Үйлдвэр, худалдааны яам, Сангийн яам, Монголбанк | 2005 | Монгол Улсын экспортын үйлдвэрлэгчид олон улсын металл, түүхий эдийн бирж болон банк, санхүүгийн байгууллагуудтай арилжаа хийх, хамтран ажиллахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулах | Эдийн засгийн байнгын хороо |
| 63 | Түүхий эд бэлтгэлийн зохицуулалтын тухай | Засгийн газар | Үйлдвэр, худалдааны яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам, Улсын мэргэжлийн хяналтын газар, Үнэт цаасны хороо | 2005 | Түүхий эдийн нийлүүлэлт, ашиглалт, тээвэрлэлт, хадгалалт, борлуулалт, чанарт тавих шаардлагыг тодорхойлж, эдгээр үйл ажиллагаанд оролцогчдын эрх, үүрэг, тавих хяналтыг тодорхойлох | Эдийн засгийн болон Хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороод |
| 64 | Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Үйлдвэр, худалдааны яам, Үндэсний аудитын газар, Монголбанк, Үнэт цаасны хороо | 2005 | Аж ахуйн нэгжийг бүртгэх үйл ажиллагааг хялбаршуулах, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр өөрчлөлт оруулах, түүнчлэн төрийн болон орон нутгийн өмчийн, тэдгээр өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн аудиторыг томилох асуудлыг Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуультай нийцүүлэх | Эдийн засгийн байнгын хороо |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 65 | Технологийн инкубаторын эрх зүйн байдлын тухай | Засгийн газар | Үйлдвэр, худалдааны яам | 2006 | Экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх, технологи, компьютерийн программ хангамж зэрэг өндөр технологийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх инкубаторын эрх зүйн байдал, төрөөс дэмжих механизмыг бүрдүүлэх | Эдийн засгийн байнгын хороо |
| 66 | Үйлдвэр, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай | Засгийн газар | Үйлдвэр, худалдааны яам | 2006 | Үйлдвэр, технологийн парк байгуулах, паркт үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдох харилцааг зохицуулах | Эдийн засгийн байнгын хороо |
| 67 | Ашигт малтмалын тухай болон Ашигт малтмалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Үйлдвэр, худалдааны яам, Монголбанк | 2005 | Төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардлын хэмжээг шинэчлэн тогтоох, ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын лицензийг шилжүүлэх тогтолцоог өөрчлөх, төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологийн судалгааны ажлын дүнгээр илэрсэн талбайд лиценз олголтыг дуудлага худалдаагаар хэрэгжүүлэх харилцааг хуульчлах | Эдийн засгийн байнгын хороо |
| 68 | Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Улсын Их Хурлын гишүүн Д.Бат-Эрдэнэ, Д.Дондог, С.Ламбаа | Улсын Их Хурлын гишүүн Д.Бат-Эрдэнэ, Д.Дондог, С.Ламбаа | 2005 | Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын лиценз олгоход тухайн аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын саналыг авахтай холбогдсон зохицуулалт оруулах | Эдийн засгийн байнгын хороо |
| 69 | Зах зээлийн хамгаалалтын арга хэмжээний тухай | Засгийн газар | Үйлдвэр, худалдааны яам, Сангийн яам | 2007 | Үндэсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг ДХБ-аас тогтоосон хэм хэмжээний дагуу хямд үнэтэй ижил төрлийн бүтээгдэхүүний импортоос хамгаалах харилцааг зохицуулах | Эдийн засгийн байнгын хороо |
| 70 | Уул уурхайн тухай | Засгийн газар | Үйлдвэр, худалдааны яам, Байгаль орчны яам | 2006 | Уул уурхайн салбарын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, хяналтын тогтолцоо, олборлолт явуулахдаа ашиглагч нь хариуцлага хүлээдэг асуудлыг тодорхой болгох, газраа заавал нөхөн сэргээдэг байх, үнэлгээ-нөхөн сэргээлт-лиценз, ашиглалт-нөхөн сэргээлт гэсэн шууд хамааралтай байх зарчмуудыг хэрэгжүүлэх | Эдийн засгийн болон Байгаль орчны байнгын хороод |
| 71 | Жижиг, дунд үйлдвэрийн эрх зүйн байдлын тухай | Засгийн газар | Үйлдвэр, худалдааны яам, Монголбанк | 2005-2007 | Жижиг, дунд үйлдвэрт тавигдах шалгуурыг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулах | Эдийн засгийн байнгын хороо |
| 72 | Мэдээллийн технологийн багц хууль | Засгийн газар | Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хууль зүй, дотоод хэргийн яам | 2005 | Мэдээлэл, холбооны технологийн хөгжлийн эрх зүйн таатай орчин бүрдүүлж, төлөвшүүлэх, төрийн мэдээллийг нээлттэй болгох, иргэд төрийн үйл ажиллагаанд хяналт тавих, электрон аргаар хөгжүүлэх, мэдээллийн технологийн тогтолцоог бий болгох | Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн хөгжлийн байнгын хороо |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 73 | Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай | Засгийн газар | Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам, | 2005 | Банкны бус санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын үйл ажиллагаанд нэгдсэн хяналт тавих, уялдуулан зохицуулах үүрэг бүхий Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлыг тогтоох | Эдийн засгийн байнгын хороо |
| 74 | Ипотекээр баталгаажсан үнэт цаасны зах зээлийн тухай | Засгийн газар | Хууль зүй, дотоод хэргийн яам, Барилга, хот байгуулалтын яам, Сангийн яам, Монголбанк, Үнэт цаасны хороо | 2005 | Ипотекээр баталгаажсан зээлийг зээлдүүлэгч байгууллагаас худалдан авах, зээлийг багцлан үнэт цаас болгон хувиргах, түүнийгээ худалдах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулах | Эдийн засгийн болон Хууль зүйн байнгын хороод |
| 75 | Дампуурлын тухай /шинэчилсэн найруулга/ | Засгийн газар | Хууль зүй, дотоод хэргийн яам, Үнэт цаасны хороо | 2005-2006 | Дампуурсанд тооцох шалгуурыг нэмэгдүүлэх, дампуурлын ажиллагаанд оролцогчдын эрх, үүргийг нарийвчлан тогтоох, хуулийн зүйл, заалтын агуулгыг тодорхой болгох, нэр томьёо, үг хэллэгийг жигдлэх зэргээр бүхэлд нь өөрчлөн найруулах | Хууль зүйн болон Эдийн засгийн байнгын хороод |
| **4.ХОТ БАЙГУУЛАЛТ, БҮС НУТАГ, ХӨДӨӨГИЙН БОДЛОГЫН ЧИГЛЭЛЭЭР** | | | | | | |
| 76 | Чөлөөт бүсийн тухай болон "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүс, "Алтанбулаг", "Цагааннуур" худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хуулиудад өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Үйлдвэр, худалдааны яам | 2005 | Тухайн хуулиар зохицуулсан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, төрийн захиргааны удирдлага, хяналтын тогтолцоог либералчлах | Эдийн засгийн байнгын хороо |
| 77 | Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Барилга, хот байгуулалтын яам, Эрүүл мэндийн яам, Шадар сайд, Улсын мэргэжлийн хяналтын газар | 2005 | Хот байгуулалтын төлөвлөгөөг бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулах, эмнэлэг, хүүхдийн байгууллага, орон сууц, усны эх булаг, голын эрүүл ахуй болон хамгаалалтын бүсэд барилга ихээр барьж, хүн амын эрүүл аюулгүй орчинд амьдрах, сурч, ажиллах эрхийг зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх механизмыг бүрдүүлэх | Дэд бүтцийн байнгын хороо |
| 78 | Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Барилга, хот байгуулалтын яам, Шадар сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар | 2005 | Нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох | Төрийн байгуулалтын байнгын хороо |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 79 | Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Барилга, хот байгуулалтын яам, Эрүүл мэндийн яам, Улсын мэргэжлийн хяналтын газар | 2005 | Хот, суурины хэрэглэгчдийг цэвэр усаар хангах, усыг ариг гамтай ашиглах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах, инженерийн барилга байгууламжийг ашиглах харилцааг боловсронгуй болгох, цэвэр, бохир усны хангагч болон хэрэглэгчийн хоорондын харилцааг зохицуулах, Усны зохицуулах газрын эрх зүйн байдлыг тогтоох, иргэд нийтийн хэрэгцээний ус түгээх байр, худгийг өөрийн эзэмшилдээ багтааж, улмаар иргэдийг усаар гачигдуулах, худалдах зэргээр хохироох, булаг шандны эх ундаргыг бохирдуулах зэрэг гарч байгаа сөрөг үр дагаваруудыг арилгах чиглэлээр нэмэлт, өөрчлөлт оруулах | Дэд бүтцийн байнгын хороо |
| 80 | Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Барилга, хот байгуулалтын яам, Улсын мэргэжлийн хяналтын газар | 2005 | Барилгын ажлыг батлагдсан зураг төслөөр, барилгын норм, стандартын дагуу гүйцэтгүүлэхэд хяналт тавих, шаардлага хангахгүй барилгын материалаар барилгын ажлыг гүйцэтгэснээр чанаргүй барилга барьж худалдан авсан хүмүүст хохирол учруулах, барилга нурах явдлыг таслан зогсоох зэрэг харилцааг зохицуулах | Дэд бүтцийн байнгын хороо |
| 81 | Геодези, зураг зүйн тухай болон Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Барилга, хот байгуулалтын яам | 2005-2008 | Газрын шинэтгэл эрчимжиж байгаагаас үүдэн газрын харилцаанд оролцож байгаа бүх субъектийн хоорондын харилцааг зохицуулах чадвар бүхий компьютержсэн үндэсний хэмжээний мэдээллийн нэгдсэн сан байгуулах, түүнд кадастрын зураглал, судалгааны ажлыг хүлээн авах, хадгалах, нэмэлт, өөрчлөлт хийхтэй холбогдсон харилцааг зохицуулах, геодези, зураг зүйн үйл ажиллагаанд мөрдөх ажлын үнэлгээ, орцын норм, жишгийг тогтоох зохицуулалт бий болгох | Дэд бүтцийн болон Эдийн засгийн байнгын хороод |
| 82 | Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Барилга, хот байгуулалтын яам | 2005 | Газрын мэдээллийн үндэсний нэгдсэн сан, газрын болон эрхийн бүртгэлийн нэгдсэн сүлжээ бий болгох чиглэлээр нэмэлт, өөрчлөлт оруулах | Эдийн засгийн болон Байгаль орчны байнгын хороод |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 83 | Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Хүнс, хөдөө аж ахуйн яам, Сангийн яам, Улсын мэргэжлийн хяналтын газар | 2005-2008 | Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах харилцааг зах зээлийн харилцаанд нийцүүлэн боловсронгуй болгох, хуулийн зарим зүйл, заалтыг бусад хуультай нийцүүлэх, малын эмийн хэрэглээ, хангамжийг зохистой байлгах, малын шимэгчтэй тэмцэхэд хэрэглэх эмийн бэлтгэн нийлүүлэлтийг төрөөс санхүүжүүлдэг зарчмыг өөрчилж, эпидемилогийн судалгаа, лабораторийн шинжилгээ, эрүүлжүүлэх хөтөлбөрийг санхүүжүүлэх талаар нэмэлт, өөрчлөлт оруулах | Хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо |
| 84 | Фермерийн аж ахуйн тухай | Засгийн газар | Хүнс, хөдөө аж ахуйн яам | 2005-2008 | Фермерийн аж ахуйн эрх зүйн байдлыг хуульчлан тогтоох, тэдгээрийн үйл ажиллагаатай холбогдон төр, иргэн, хуулийн этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулах | Хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо |
| 85 | Ургамал хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Хүнс, хөдөө аж ахуйн яам, Байгаль орчны яам, Улсын мэргэжлийн хяналтын газар | 2005-2008 | Ургамал хамгааллын албаны бүтэц, үйл ажиллагааг зах зээлийн шаардлагад нийцүүлэн хуульчлах | Хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо |
| 86 | Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Хүнс, хөдөө аж ахуйн яам, Эрүүл мэндийн яам, Үйлдвэр, худалдааны яам, Сангийн яам, Улсын мэргэжлийн хяналтын газар | 2005 | Хүнсний аюулгүй байдлын хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, хоол хүнсээр дамжих өвчний бүртгэл, тандалт, мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх, биологийн идэвхт нэмэлт хүнсний бүтээгдэхүүний бүртгэл, импорт, үйлдвэрлэл, худалдаа, хүнсний аюулгүй байдлын шаардлага хангаагүй үйлдвэр, аж ахуйн нэгжид авах захиргааны арга хэмжээг өнөөгийн шаардлагад нийцүүлэх, нутаг дэвсгэрийн хүн амыг чанартай, аюулгүй хүнсний бүтээгдэхүүнээр хангахад орон нутгийн засаг захиргааны үүрэг, хариуцлага, урамшууллын асуудлыг тодорхой болгохтой холбогдох харилцааг зохицуулах | Хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо |

5.БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГЫН ЧИГЛЭЛЭЭР:

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 87 | Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Барилга, хот байгуулалтын яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам, Байгаль орчны яам, Улсын мэргэжлийн хяналтын газар, Үйлдвэр, худалдааны яам | 2005 | Бэлчээр, хадлан, тариалангийн газрын зохицуулалтыг боловсронгуй болгох, тухайлбал, фермерийн аж ахуй, эрчимжсэн мал аж ахуй эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжид бэлчээр эзэмшүүлэх асуудлыг хуульчлах, усалгаатай тариалангийн зориулалтаар атар газар эзэмшихэд дэмжлэг үзүүлэх, түүнчлэн зохих зөвшөөрөлгүйгээр барилга, байгууламж барьсан, эсхүл бусад хэлбэрээр дур мэдэн эзэмшсэн бол уг газрыг албадан чөлөөлөх эрх зүйн үндэс бий болгох, чөлөөт бүсүүдэд хөрөнгө оруулагч нарт чөлөөт бүсэд олгосон газрыг дамжуулан түрээслэх харилцааг зохицуулах | Байгаль орчны болон Дэд бүтцийн байнгын хороод |
| 88 | Газрын төлбөрийн тухай /шинэчилсэн найруулга/ | Засгийн газар | Барилга, хот байгуулалтын яам, Зам тээвэр, аялал жуулчлалын яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Байгаль орчны яам, Улсын мэргэжлийн хяналтын газар | 2005-2006 | Төрийн өмчийн газрыг бусдад эзэмшүүлж, ашиглуулсны төлбөр ногдуулах, түүнийг улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэхтэй холбогдсон харилцааг боловсронгуй болгох, түүнчлэн газрын төлбөрийн хэмжээг газрын үр өгөөж, байршилтай уялдуулан ялгавартай тогтоох | Байгаль орчны, Төсвийн болон Дэд бүтцийн байнгын хороод |
| 89 | Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Барилга, хот байгуулалтын яам | 2005-2008 | Иргэдэд өмчлүүлсэн газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах нөхцөлөөр хангах, газар өмчлөлийн мэдээлэл, бүртгэлийг иргэдэд нээлттэй байлгах | Байгаль орчны болон Эдийн засгийн байнгын хороод |
| 90 | Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Барилга, хот байгуулалтын яам | 2005 | Гэр бүлийн хамтын хэрэгцээний зориулалтаар газрыг үнэ төлбөргүйгээр өмчлүүлэх хугацааг 2008 он хүртэл үргэлжлүүлэн сунгах | Байгаль орчны, Эдийн засгийн болон Дэд бүтцийн байнгын хороод |
| 91 | Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Байгаль орчны яам | 2005-2006 | Хуурайшилттай болон гантай жилүүдэд ойгоос түлээний болон аж ахуйн зориулалтаар мод бэлтгэх харилцааг зохицуулах | Байгаль орчны байнгын хороо |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 93 | Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Байгаль орчны яам, Эрүүл мэндийн яам, Сангийн яам | 2005-2006 | Байгалийн ус, рашаан ашигласны төлбөр төлөх харилцааг боловсронгуй болгох | Байгаль орчны болон Төсвийн байнгын хороод |
| 94 | Био аюулгүй байдлын тухай | Засгийн газар | Байгаль орчны яам | 2005 | Хувиргасан амьд организм, түүний гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх, зохистой ашиглах, хүний эрүүл мэнд, амьтан, ургамлын биологийн төрөл зүйлийн аюулгүй байдлыг хамгаалах | Байгаль орчны байнгын хороо |
| 95 | Байгалийн ургамал ашигласны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Байгаль орчны яам | 2005-2006 | Байгалийн ургамал ашигласны төлбөрийн хэмжээг ургамлын төрөл, ангилалтай уялдуулан өөрчлөх | Байгаль орчны болон Төсвийн байнгын хороод |
| 96 | Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Байгаль орчны яам | 2005-2006 | Иргэд оршин суугаа нутаг дэвсгэрийнхээ байгаль орчин, түүний баялгийг хамгаалалтандаа авах, байгаль хамгаалагч, улсын байцаагчийн ажиллах баталгааг сайжруулах | Байгаль орчны байнгын хороо |
| 97 | Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Байгаль орчны яам | 2005 | Амьтны тоо толгойн хомсдол, тархалт байдлыг харгалзан зах зээлийн өнөөгийн нөхцөлд мөнгөний өсөлттэй уялдуулан хураамжийн хэмжээг нэмэгдүүлэх | Байгаль орчны болон Төсвийн байнгын хороод |
| 98 | Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Байгаль орчны яам | 2005 | Ойг хамгаалах, нөхөн сэргээх, модны ашиглалтыг хязгаарлах, ойн экологийн тэнцвэрийг хадгалах зорилгоор төлбөрийг нэмэгдүүлэх | Байгаль орчны болон Төсвийн байнгын хороод |
| 99 | Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь хэмжээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Барилга, хот байгуулалтын яам, Үйлдвэр, худалдааны яам, Байгаль орчны яам | 2005-2006 | Нөхөн сэргээлтийн хөрөнгийн зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, ашигт малтмал олборлосноос олсон орлогын зохих хувийг газрын нөхөн сэргээлтэнд зарцуулах хөрөнгийг тусгай санд төвлөрүүлэх чиглэлээр нэмэлт, өөрчлөлт оруулах, түүнчлэн байгалийн бусад нөөц баялгийг ашигласны орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд зарцуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох | Төсвийн болон Байгаль орчны байнгын хороод |

6.АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН ЧИГЛЭЛЭЭР:

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 100 | Дипломат албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Гадаад хэргийн яам | 2005-2006 | Дипломат албыг төрийн тусгай албаны хувьд мэргэжлийн өндөр ур чадвартай албан хаагчдаар хангах эрх зүйн үндсийг бүрдүүлэх, мөн эдгээр албан хаагчдын нийгмийн болон бусад баталгаат хуульчлан хангах | Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо |
| 101 | Хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Хууль зүй, дотоод хэргийн яам, Батлан хамгаалах яам | 2007-2008 | Олон улсын агаарын замын боомтод улсын хилийн шугамыг холбогдох байгууллагууд хамтран тогтоож мөрдөг журмыг хуульчлах, улсын хилийг агаарын хөлгөөр нэвтрэх харилцааг боловсронгуй болгох | Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо |
| 102 | Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Батлан хамгаалах яам | 2006 | Иргэн гэрээгээр цэргийн алба хаах нөхцөл боломжоог дээшлүүлэх, дүйцүүлэх алба хаах болзол журмыг боловсронгуй болгох, алслагдсан анги, байгууллагад ажиллаж буй цэргийн албан хаагчдын нийгмийн баталгааг дээшлүүлэх | Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо |
| 103 | Дайны байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Батлан хамгаалах яам | 2005-2008 | Дайны үед дагаж мөрдөх хууль тогтоомжийг тайван цагт баталж хадгалах | Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо |
| 104 | Батлан хамгаалах тухай болон Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Батлан хамгаалах яам | 2006 | Эдгээр хуулийг хооронд нь уялдуулах, хэрэгжихгүй байгаа зүйл, заалтуудыг өөрчлөх, түүнчлэн зарим зохицуулалтыг нэмж тусгах | Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо |
| 105 | Тагнуулын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Тагнуулын ерөнхий газар | 2005-2006 | Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хууль, бусад хуультай нийцүүлэх, нууц ажиглалтын албаны ажилтны нийгмийн баталгаат сайжруулах, тагнуулын байгууллагын ажилтан нь улс төрийн зорилгоор эвлэлдэн нэгдэх, улс төрийн үйл ажиллагаа явуулдаг эвсэл, холбооны гишүүн байх, албан үүрэгтэйгээ холбоотой ямар ч мэдээ баримтыг улс төрийн зорилгоор ашиглахыг хориглох талаар тусгах | Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо |
| 106 | Гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Тагнуулын ерөнхий газар | 2005-2006 | Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хууль, холбогдох бусад хуультай нийцүүлэх | Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 107 | Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Тагнуулын ерөнхий газар | 2005-2006 | Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн нийгмийн баталгааг сайжруулах, Тагнуулын байгууллагын тухай болон бусад хуультай нийцүүлэх | Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо |
| **7.ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ, ТҮҮНИЙ ХУУЛЬ ЗҮЙН БАТАЛГААГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР:** | | | | | | |
| 108 | Ашгийн бус хуулийн этгээдийн тухай | Засгийн газар | Хууль зүй, дотоод хэргийн яам | 2005 | Ашгийн бус хуулийн этгээдийн эрх зүйн байдал, нийгэмд үйлчилдэг байгууллагын статусыг тодорхойлох | Хууль зүйн байнгын хороо |
| 109 | Нотариатын тухай /шинэчилсэн найруулга/ | Засгийн газар | Хууль зүй, дотоод хэргийн яам | 2005 | Нотариатын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгох. Тухайлбал, нотариатчийн үүрэг, хариуцлагыг нарийвчлан тодорхойлох, олон улсын жишиг, зарчимд нийцүүлэх | Хууль зүйн байнгын хороо |
| 110 | Төлбөрт таавар, бооцоот тоглоомын тухай | Засгийн газар | Хууль зүй, дотоод хэргийн яам | 2005 | Төлбөрт таавар, бооцоот тоглоомын төрлийг тогтоох, тухайн төрлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хяналт тавихтай холбогдон үүсэх харилцааг зохицуулах | Хууль зүйн байнгын хороо |
| 111 | Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Хууль зүй, дотоод хэргийн яам | 2005 | Хуулийн зарим зүйлд сонгох ял бий болгох, насанд хүрээгүй этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг тухайлан авч үзэх, ял шийтгэлийн хэмжээг гэмт хэргийн ангилалд нийцүүлэх, мөн хүүхдийн эрхийн талаарх олон улсын гэрээ, хэлэлцээрт нийцүүлэн зарим нэмэлт, өөрчлөлт оруулах | Хууль зүйн байнгын хороо |
| 112 | Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Хууль зүй, дотоод хэргийн яам | 2005 | Хуулиар зохицуулж буй зарим харилцааг тодруулах, оновчтой болгох, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцийн заалтад нийцүүлэх зэргээр хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох | Хууль зүйн байнгын хороо |
| 113 | Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Хууль зүй, дотоод хэргийн яам | 2005 | Хуулийн зарим заалтын уялдаа холбоог сайжруулах, хоёрдмол утгаар ойлгож болох нэр томъёо, үг, өгүүлбэр, хэсэг, заалтуудыг өөрчлөх, тусгаагүй зарим харилцааг нэмж тусгах зэргээр хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох | Хууль зүйн байнгын хороо |
| 114 | Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Хууль зүй, дотоод хэргийн яам | 2005 | Хуулийн зарим зүйл, заалтын агуулгыг нарийвчлан тодруулах, хоёрдмол утгаар ойлгож болох нэр томъёо, үг, өгүүлбэр, хэсэг, заалтуудыг өөрчлөн сайжруулах, давхардсан заалтыг хасах, хүчингүй болгох зэргээр хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох | Хууль зүйн байнгын хороо |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 115 | Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Хууль зүй, дотоод хэргийн яам | 2006 | Торгуулийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулан тогтоох, гадаадын иргэнд хариуцлага хүлээлгэх, захиргааны зөрчлийн харьяаллыг тодорхой болгох | Хууль зүйн байнгын хороо |
| 116 | Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай /шинэчилсэн найруулга/ | Засгийн газар | Хууль зүй, дотоод хэргийн яам | 2007 | Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албаны тогтолцоог боловсронгуй болгох, мөн түүнчлэн уг хуульд олон дахин өөрчлөлт оруулсныг харгалзан нэр томъёо, үг хэллэгийг жигдлэх зэргээр хуулийг бүхэлд нь өөрчлөн найруулах | Хууль зүйн байнгын хороо |
| 117 | Харьяатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Хууль зүй, дотоод хэргийн яам, Гадаад хэргийн яам | 2006 | Хоёрдмол харьяаллыг хязгаарлагдмал хүрээнд хүлээн зөвшөөрөх талаар нэмэлт, өөрчлөлт оруулах | Хууль зүйн байнгын хороо |
| 118 | Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Хууль зүй, дотоод хэргийн яам, Гадаад хэргийн яам | 2007 | Монгол Улсын иргэн гадаадад цагаачлах зөвшөөрөл олгох, гадаадад зорчих, цагаачлах болон удаан хугацаагаар хөдөлмөрлөж, суралцаж байгаа иргэдийн эрх ашгийг хамгаалах, тэдэнд эрх зүйн туслалцаа үзүүлэх, гадаадад байгаа иргэдийг бүртгэхтэй холбогдсон харилцааг зохицуулах | Хууль зүйн байнгын хороо |
| 119 | Авилгалын эсрэг хууль /шинэчилсэн найруулга/ | Улсын Их Хурлын гишүүд | Улсын Их Хурлын гишүүд, Хууль зүй, дотоод хэргийн яам | 2005-2008 | Авилгалаас урьдчилан сэргийлэх, тэмцэхтэй холбогдсон үйл ажиллагааг нарийвчлан зохицуулах, төрийн албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийг нээлттэй болгох, түүнд тавих хяналтын механизмыг боловсронгуй болгох | Хууль зүйн байнгын хороо |
| 120 | Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай | Засгийн газар | Хууль зүй, дотоод хэргийн яам, Монголбанк, Үнэт цаасны хороо | 2005 | Банк, банк бус санхүүгийн байгууллагаас зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээний үүрэгтэй холбогдуулан ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах | Хууль зүйн байнгын хороо |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 121 | Иргэний бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Хууль зүй, дотоод хэргийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Гадаад хэргийн яам | 2005 | Иргэний бүртгэл, мэдээллийн орон нутгийн байгууллагын тогтолцоог шууд босоо удирдлагатай болгож, үйл ажиллагааны нэгдмэл зарчимд шилжих, иргэний бүртгэл, мэдээллийн цахим сангийн аюулгүй ажиллагааг хангах,_ түүнчлэн Монгол Улсын иргэн иргэний үнэмлэх авахдаа тангараг өргөдөг байхаар нэмэлт оруулах, үндэсний гадаад паспортыг олгох, хадгалах, хамгаалах, иргэний овог, эцгийн нэр, нэр өөрчлөх, хүүхэд үрчлэхтэй холбогдсон харилцааг боловсронгуй болгох | Хууль зүйн байнгын хороо |
| 122 | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Хууль зүй, дотоод хэргийн яам | 2005 | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар иргэн, байгууллагын хүлээх үүргийг нарийвчлан тусгах, иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний санхүүжилтийг тодорхой болгох | Хууль зүйн байнгын хороо |
| 123 | Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Улсын Их Хурлын гишүүн Д.Дондог, Р.Раш | Улсын Их Хурлын гишүүн Д.Дондог, Р.Раш | 2005 | Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг чангатгах | Хууль зүйн байнгын хороо |
| 124 | Мэдээллийн эрх чөлөөний тухай | Засгийн газар | Хууль зүй, дотоод хэргийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар | 2006-2008 | Хуулиар хамгаалагдсан нууцад хамаарахаас бусад мэдээлэл нээлттэй байх, мэдээлэл авах хэлбэрүүдийг тусган, байгууллага, албан тушаалтан, иргэний эрх, үүргийг тодорхойлох | Хууль зүйн байнгын хороо |
| 125 | Зохиогчийн эрхийн тухай болон Патентын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар | Шадар сайд, Оюуны өмчийн газар | 2005-2008 | Шинэ бүтээл, оюуны өмчийн эрхийн хамгаалалтыг сайжруулах, оюуны өмч эзэмшигч, ашиглагчдын хоорондын харилцааг боловсронгуй болгох, оюуны бүтээлийг хамтран өмчлөгчдийн эрх, үүргийг тодорхой болгох, эрх ашгийг нь хамгаалах, шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох | Хууль зүйн байнгын хороо |
| | **Хоёр.МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ** | | | | | |
| 1 | Усны талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай | Засгийн газар | Байгаль орчны яам | 2005 | Усны эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хамгаалах, зүй зохистой ашиглах, хүн ам, мал аж ахуй, үйлдвэрийг чанарын шаардлага хангасан усаар хангах, байгалийн гол мөрөн, нуурын усыг зохистой ашиглах зэрэг асуудлыг зохицуулах | Байгаль орчны байнгын хороо |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2 | Албан бус хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн үйл ажиллагааны талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай | Засгийн газар | Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Сангийн яам, Үйлдвэр, худалдааны яам | 2005 | Албан бус хэвшлийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, ОУХБ-ын хөдөлмөрийн хүрээний үндсэн эрх, суурь зарчмууд хэрэгжих боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн бодлогыг зохицуулах | Нийгмийн бодлогын байнгын хороо |
| 3 | Импортын барааны гаалийн албан татварын хэмжээ тогтоох тухай | Засгийн газар | Үйлдвэр, худалдааны яам, Сангийн яам | 2005-2006 | "Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээг батлах тухай" Улсын Их Хурлын 1999 оны 27, 2000 оны 51 дүгээр тогтоолыг өнөөгийн нөхцөл байдалтай уялдуулан өөрчлөх | Төсвийн байнгын хороо |
| 4 | Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай | Засгийн газар | Онцгой байдлын ерөнхий газар | 2005 | Төрөөс гамшгаас хамгаалах талаар баримтлах үзэл баримтлалыг бий болгох, гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлтгэл, бэлэн байдлыг дээшлүүлэх, аврах, сэргээн босгох үйл ажиллагааны шуурхай байдлыг хангах, сургалт, дадлагажуулалт, гамшгийн нөөц бүрдүүлэх тогтолцоо бий болгох | Аюулгүй байдал, гадаад бодлогын болон Төрийн байгуулалтын байнгын хороод |
| 5 | Гамшгаас хамгаалах хөтөлбөр батлах тухай | Засгийн газар | Онцгой байдлын ерөнхий газар | 2005-2006 | Гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох ажиллагаанд оролцох гамшгаас хамгаалах байгууллага болон төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын харилцан ажиллагааг уялдуулан тогтоох | Аюулгүй байдал, гадаад бодлогын болон Төрийн байгуулалтын байнгын хороод |
| 6 | Бүлэг суурингийн тогтолцоог батлах тухай | Засгийн газар | Барилга, хот байгуулалтын яам | 2005 | Хүн амын нутагшилт, хөгжлийн ерөнхий төслийн хүрээнд бүсчилсэн хөгжлийн стратеги зорилтыг хэрэгжүүлэх, бүлэг суурингийн зөв тогтолцоог тогтоох, бүлэг суурингийн төвүүдийг тодорхойлох | Төрийн байгуулалтын болон Дэд бүтцийн байнгын хороод |
| 7 | 2005-2008 онд Монгол Улсад оруулж болох цагаач иргэдийн тоо, бүтэц болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид оршин суух цагаач иргэдийн тоог тогтоох тухай | Засгийн газар | Хууль зүй, дотоод хэргийн яам | 2005 | Монгол Улсад оршин суугаа буй гадаадын иргэд, түүний дотор хувийн хэргээр удаан хугацаагаар болон байнга оршин суугч, цагаач иргэдийн тооны зохистой хязгаар, байршлыг тогтоох | Хууль зүйн байнгын хороо |
| 8 | Төрийн өмчийг 2005-2008 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай | Засгийн газар | Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Бусад яамд | 2005 | Үнэ цэнэ бүхий томоохон аж ахуйн нэгжүүдийн хувьчлалыг үргэлжлүүлэх | Эдийн засгийн байнгын хороо |
| 9 | Сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөр батлах тухай | Засгийн газар | Түлш, эрчим хүчний яам | 2005 | Эрчим хүчний хангамжид сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг нэмэгдүүлэх, хөдөөгийн эрчим хүчний хангамжийг сайжруулах, хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг хангах нөхцлийг бүрдүүлэх | Дэд бүтцийн байнгын хороо |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 10 | Ногоон хэрэм хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай | Засгийн газар | Байгаль орчны яам | 2005 | Цөлжилт, хуурайшилт, хээршилт, шар шороон шуургыг багасгах, говь, хээрийн бүсийн ногоон массын талбайн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор "Ногоон хэрэм" хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөрөнгө, санхүүжилтийн эх үүсвэрийн асуудлыг зохицуулах | Байгаль орчны байнгын хороо |
| 11 | Ёс зүйн дэд хорооны дүрэм батлах тухай | Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Л.Гантөмөр, Д.Дэмбэрэл | Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Л.Гантөмөр, Д.Дэмбэрэл | 2005 | Улсын Их Хурлын тухай хуулийн 16.3-ыг үндэслэн Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, дотоод зохион байгуулалтын асуудлыг тодотгон зохицуулах | Төрийн байгуулалтын байнгын хороо |
| 12 | Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм батлах тухай | Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Л.Гантөмөр, Д.Дэмбэрэл | Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Л.Гантөмөр, Д.Дэмбэрэл | 2005 | Төрийн албаны тухай хуулийн 10.2-ыг үндэслэн Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн хэм хэмжээг тогтоох | Төрийн байгуулалтын байнгын хороо |
| 13 | Төрийн өндөр албан тушаалтны ёс зүйн дүрэм батлах тухай | Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Л.Гантөмөр, Д.Дэмбэрэл | Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Л.Гантөмөр, Д.Дэмбэрэл | 2005 | Төрийн албаны тухай хуулийн 10.2-ыг үндэслэн Улсын Их Хурлын гишүүнээс бусад төрийн өндөр албан тушаалтны ёс зүйн хэм хэмжээг тогтоох | Төрийн байгуулалтын байнгын хороо |
| 14 | Дархан цаазат Богд хаан уулын хилийн заагийг өөрчлөн тогтоох тухай | Улсын Их Хурлын гишүүн Ж.Гүррагчаа | Улсын Их Хурлын гишүүн Ж.Гүррагчаа | 2005-2006 | Тус Дархан цаазат газарт аж ахуйн ашиглалтын ачаалал ихэссэнтэй холбогдуулан хилийн заагийг нь холбогдох хуульд нийцүүлэн өөрчлөн тогтоох | Байгаль орчны байнгын хороо |
| 15 | Хот, суурин газрын түлшний талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай | Улсын Их Хурлын гишүүн Л.Пүрэвдорж | Улсын Их Хурлын гишүүн Л.Пүрэвдорж, Түлш, эрчим хүчний яам | 2005-2007 | Хот, суурин газрын түлшний талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох | Дэд бүтцийн байнгын хороо |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 16 | Соёл, урлагийн гадаад сурталчилгааны үндсэн чиглэл батлах тухай | Засгийн газар | Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам | 2005 | Үндэсний соёл, урлагийг гадаад улсад сурталчлахад баримтлах бодлогыг тодорхойлоход төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг тогтоох | Боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо |
| 17 | Энергийн талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай | Улсын Их Хурлын гишүүн Ж.Наранцацралт, Ц.Дамиран | Түлш, эрчим хүчний яам | 2005-2006 | Монгол Улсаас энергийн талаар баримтлах бодлогыг тодорхойлох | Дэд бүтцийн байнгын хороо |
| 18 | "Дөчин мянган орон сууц" хөтөлбөр батлах тухай | Засгийн газар | Барилга, хот байгуулалтын яам | 2005 | Хүн амыг орон сууцаар хангах, орон сууц барих ажлыг эрчимжүүлэх | Дэд бүтцийн байнгын хороо |
| 19 | Үйлдвэр-хотуудын талаар авах арга хэмжээний хөтөлбөр батлах тухай | Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Д.Одхүү | Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Д.Одхүү | 2006-2007 | Үйлдвэр-хотуудын онцлог чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх эдийн засгийн үндэс, хотуудаас аж ахуйн нэгж, байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгжтэй харилцах зэрэг асуудлыг тусгах | Төрийн байгуулалтын болон Дэд бүтцийн байнгын хороод |
| 20 | Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс тогтмол зарлаж байх тухай | Улсын Их Хурлын гишүүн Г.Адъяа, Р.Амаржаргал, С.Ламбаа | Улсын Их Хурлын гишүүн Г.Адъяа, Р.Амаржаргал, С.Ламбаа | 2005 | Инфляцийг тодорхойлж буй хэрэглээний сагсны бүтэц нь хүн амын зарим хэсгийн хэрэглээг бүрэн илэрхийлж чадахгүй байгаа тул хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, хөдөлгөөнийг судлан сар бүр нийтэд мэдээлж байх | Нийгмийн бодлогын болон Төсвийн байнгын хороод |

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
"Төрийн Мэдээлэл" эмхэтгэлийн зөвлөл
Улаанбаатар-12,
Төрийн ордон
☎ 329612
Индекс 14003

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.
☎ 329487
Хэвлэлийн хуудас 3.5